

## ХАРААТ БУС ХЯНАГЧ-НЭГТГЭГЧИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

Монгол Улсын ОУИТБС-ын 2014 оны нэгдсэн тайлан боловсруулах “Хараат бус хянагч-нэгтгэгчийн ажлын даалгавар”

Ажлын хэсгийн баталсан огноо: 2015 оны 3 дугаар сарын 11-ны өдөр

### Хураангуй

Энэхүү баримт бичиг нь 2014 оны 1 дүгээр сард ОУИТБС-ын Удирдах зөвлөлөөс баталсан ОУИТБС-ын стандарттай нийцэх Хараат бус хянагч-нэгтгэгчийн үйлчилгээнд тавих загвар-ажлын даалгаварыг агуулсан болно.

Ажлын даалгаварт Хараат бус хянагч-нэгтгэгчийн гүйцэтгэх ажлыг тусгадаг. Энэхүү баримт бичгийг Засгийн газар болон Хараат бус хянагч-нэгтгэгчийн хооронд байгуулах гэрээнд хавсаргана. Энэхүү ажлын даалгаварыг (шаардлага 5.2-ийн дагуу) Олон талт ажлын хэсэг (цаашид ОТАХ гэнэ)-ээр батлуулдаг журамтай.

ОУИТБС-ын жил бүрийн тайлагналд тавих ОТАХ-ийн хяналтын талаарх зааварчилгааг боловсруулж, ОТАХ болон ажлын албаны зүгээс энэхүү загварыг бөглөхөөс өмнө тодорхой асуудлуудыг шийдвэрлэх, ОУИТБС-ын стандарттай нийцүүлэх зорилгоор тайлагналын процессд хяналт тавихад зааварчилгаа үзүүлэх зорилготой юм. Загварыг ашиглах нь бүрэн нийцлийг хангасан баталгаа биш юм. Гэхдээ ОТАХ нь тайлагналын ажиллагааг нарийн чамбай, бүрэн бүтэн мөн найдвартай байлгах нөхцлөөр хангах үүрэгтэй юм.

Энэ загварын Хэсэг 4-т ОУИТБС-ын тайлагналд “батлагдсан горим”-ыг (шаардлага 5.2) агуулсан болно. “Батлагдсан горим”-д тайлагналын процесст хэрэгжүүлэх гол алхамуудыг хамрах ОУИТБС-ын Олон улсын Удирдах зөвлөлөөр (цаашид Удирдах Зөвлөл гэнэ) батлуулан стандартчилсан горимыг хэлнэ. Уг алхамуудад ОУИТБС-ын тайлагналын хамрах хүрээг тогтоох, тайлагналын загвар/маягтуудыг боловсруулах, өгөгдөл мэдээллийг баталгаажуулах, цуглуулах мөн ОУИТБС-ын шаардлагуудын дагуу зөрүүнд дүн шинжилгээ хийх тус тус хамрагдах болно. Удирдах зөвлөл нь ОУИТБС-ын тайлагналыг жигд, найдвартай болгох үүднээс энэхүү горимыг боловсруулсан юм.

Удирдах зөвлөл нь аль болох одоо байгаа горим, бүтцэд тулгуурлан энэхүү ажиллагааг явуулахыг зөвлөдөг билээ. Өгөгдөл мэдээлэл цуглуулах, тайлагнах болон аудит тавихад одоо ашиглаж буй тогтолцоонд хувь нэмэр оруулах, үнэлэх мөн сайжруулах зорилгоор ОУИТБС-ыг ашиглана. Ингэснээр ОУИТБС-ыг ашиглан бусад хяналтын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэгдсэн чухал зөвлөмжүүдийг гаргах боломжтой юм.

ОТАХ нь өөрийн ажлын төлөвлөгөөний дагуу Хараат бус хянагч-нэгтгэгчээр хийлгүүлэх нэмэлт ажил, зорилтуудыг энэхүү загварт оруулах боломжтой юм.

### 1. Оршил

ОУИТБС-ын хэрэгжилт нь хоёр үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэнэ:

- Ил тод байдал: газрын тос, байгалийн хий болон ашигт малтмалын компаниуд нь засгийн газарт төлсөн төлбөрөө, засгийн газар хүлээн авсан төлбөрөө ил болгоно. Эдгээр тоон баримтыг Хараат бус хянагч-нэгтгэгч нэгтгэж, нэгтгэсэн дүнг ОУИТБС-ын жилийн тайланд олборлох салбарын нөхцөл байдал болон бусад мэдээлэлтэй хамт хэвлэнэ.
- Хариуцлага: засгийн газар, компаниуд болон иргэний нийгмийн төлөөллөөс бүрдэх олон

талт ажлын хэсэг ОУИТБС-ын тайланг боловсруулах явцад хяналт тавих, үр дүнг нийтэд түгээх, тухайн улс дахь ил тод байдлыг нэмэгдүүлэх нийтлэг чармайлттай уялдуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор байгуулагдана.

ОУИТБС-ын тайлагналын бүрэн бүтэн байдал, иргэдийн дунд орлогын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, олон нийт, засгийн газар болон хувийн хэвшлийн ил тод, хариуцлагатай байх өндөр стандартыг хөхиүлэн дэмжихэд чиглэгдсэн ОУИТБС-ын хэрэгжилтийг өргөжүүлэх шинэлэг арга барилыг ОТАХ баримтлахыг ОУИТБС-ын стандарт дэмждэг. ОТАХ нь ажлын төлөвлөгөөнд тусгасан ОУИТБС-ын зөвшилцсөн хамрах хүрээ, зорилтуудад суурилан Хараат бус хянагч-нэгтгэгчийн ажлын даалгаварыг батлах (шаардлага 5.2) шаардлагатай. ОТАХ нь эдгээр асуудлуудыг өөрийн дотоод засаглалын дүрэм, горимын дагуу хэлэлцэж, шийдвэрлэх юм (шаардлага 1.3-г харна уу). ОУИТБС нь оролцогч тал бүрийн тэгш түншлэлийн оролцоог хангасан шийдвэр гаргах хэрэгжилтийн бүхий л үед баримтлахыг шаарддаг.

Хараат бус хянагч-нэгтгэгч нь сайн, итгэл даахуйц, мэргэжлийн хувьд чадвартай гэсэн дүгнэлт олон талт ажлын хэсгээс авч чадсан байх шаардлагатай (шаардлага 5.1). Олон талт ажлын хэсэг болон Хараат бус хянагч-нэгтгэгч нь ашиг сонирхлын зөрчилтэй холбогдолтой аливаа асуудлыг авч үзэх нь зүйтэй. Хараат бус хянагч-нэгтгэгчийн тайланг [ОТАХ]-ээр батлуулахаар өгч, улмаар нийтэд ил болгоно.

Хэрэгжүүлэгч орнуудад тавигдах шаардлагуудыг ОУИТБС-ын стандартад тусгасан болно<sup>1</sup>. Нэмэлт мэдээллийг [www.eiti.org](http://www.eiti.org) -с авна уу.

Энэ ажлын даалгаварт ОУИТБС-ын шанаачлагын шаардлага 5.2-т заасан ОУИТБС-ын тайлагналын (хэсэг 4-ийг харна уу) “батлагдсан процедур”-ыг тусгасан байна. Удирдах зөвлөл нь ОУИТБС-ын тайлагналыг илүү жигд, найдвартай болгох үүднээс эндгээр процедурыг боловсруулсан юм. ОУИТБС-ын процессийг одоо байгаа тайлагнал болон аудитын тогтолцоонд нэмэх, үнэлэх болон сайжруулах зорилгоор ашиглаж болох юм. Удирдах зөвлөл нь энэхүү процессийг аль болох одоо байгаа процедур, институциудад тулгуурлан явуулах, өөрөөр хэлбэл одоо байгаа дата цуглуулах, аудит хийх тогтолцоотой уялдуулах, сайтар үнэлэх, сайжруулахад ОУИТБС-ын процессийг чиглүүлэхийг зөвлөдөг. Ингэснээр ОУИТБС-ын процессийг ашиглан бусад хяналтын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэгдсэн чухал зөвлөмжүүдийг гаргах боломжтой юм.

### ***Монгол Улс дахь ОУИТБС-ын хэрэгжилт***

Монгол Улсын Засгийн газраас ОУИТБС-д нэгдэх шийдвэрээ 2006 онд анх гаргасан билээ. Үүний дагуу ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, ажлын хэсгийг Засгийн газар, уул уурхайн компани, иргэний нийгмийн төлөөлөгчдийг оролцуулан байгуулж, ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үүргийг хүлээлгэсэн байна. Монгол Улсын ОУИТБС-ын 2006-2009 оны нэгдсэн тайлан гаргах зардлыг олон талт хандивлагчдын Итгэлийн сангаас санхүүжүүлсэн бол Монгол Улсын Засгийн газар 2010 оны аудитын тайлан нэгтгэлийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж эхлэсэн бөгөөд одоо жил бүр улсын төсвөөс гаргаж байна.

Олон талт оролцогчдын ажлын хэсэг нь цомхон ажлын албаны туслалцаатайгаар ОУИТБС-ын ажлын төлөвлөгөөг боловсруулан Үндэсний зөвлөлөөр батлуулж, уул уурхайн болон газрын

<sup>1</sup> <http://eiti.org/document/standard>

тосны үйлдвэрлэл явуулж байгаа болон хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий компаниудаас бүх шатны (улс, аймаг, дүүрэг, сум) төсөвт төлсөн төлбөр, Засгийн газар тэдгээр компаниудаас хүлээн авсан орлогын тайланг гаргуулж байна. Тайлангийн маягтуудыг анх 2007 онд гаргаж, 2008, 2011, 2012 оны сүүлчээр шинэчлэн батлуулж, ашиглаж байна. 2012 оноос эхлэн орон нутгийн захиргааны байгуулага компани хооронд байгуулсан гэрээг ил тод болгохыг зорьж 2012, 2013 оны тайланд гэрээ байгуулсан эсэхэд үнэлгээ хийж нэгдсэн тайланд тусгасан болно. 2015 оны 1 дүгээр сарын 1- нээс эхлэн компани, Засгийн газрын оролцогч байгууллагууд цахимаар тайлагнаж байна.

Монгол Улсын 2006 оны нэгдсэн тайланг Австралийн Крейн Уайт энд Ассоушиэтс хэмээх аудиторын компаниар, 2007 оны тайланг Монгол, Малайзийн Эрнст Янг аудитын компаниудын консерцум, бол 2008, 2009, 2010, 2011, 2013 оны тайланг Их Британийн Харт Нойрс лдт, Монгол Улсын Улаанбаатар аудит корпорацийн консерцум гаргаж, харин 2012 оны тайланг Их Британийн Мүүр Стефенс, Монгол Улсын Далайван аудит компаниудын консерцум гаргасан байна. Манай улсад ОУИТБС-ын тайлан гаргах үйл ажиллагаа жилээс жилд өсөн нэмэгдэж, нэгтгэл тайлангаар гарах зөрүү тогтвортой буурч байна. Тайланд хамрагдсан байдлыг харуулбал:

Он	Тайлан гаргасан компани	Сангийн яамнаас гаргасан тайланд компанийн хамрагдалт	Монгол Улсын нэгдсэн тайланд орсон компани	Нэгтгэгдсэн дүн (төгрөг)	Улсын төсвийн урсгал орлогын	Цэвэр зөрүү (төгрөг)
2006	64	137	25	492 тэрбум	36 хувь	4 тэрбум
2007	102	184	38	745 тэрбум	40 хувь	775 сая
2008	115	184	46	686 тэрбум	32 хувь	420 сая
2009	129	363	101	737 тэрбум	37 хувь	58 сая
2010	274	477	150	1275 тэрбум	48 хувь	356 мянга
2011	301	518	200	2150 тэрбум	54 хувь	75 сая
2012	1531	1829	200	1594 тэрбум	33 хувь	360 сая
2013	1617	1198	250	1576 тэрбум	27 хувь	37 сая
2014						

Тайлбар: 1.2007 онд мөн 2 талдаа тайлан гарсан 28 компанийн тайланг Сангийн яамнаас гаргасан тайлантай нэгтгэх ажлыг Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын баг 2008 оны 8 дугаар сард явуулж дүнг Ажлын хэсэгт танилцуулж, сайшаагдсан байна.

Монгол Улсын энэхүү санаачлагыг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан үйл ажиллагаа, түүний үр дүнд баталгаажуулалт хийсэн дүнг ОУИТБС-ын олон улсын удирдах хороо хэлэлцэн

2010 оны 10 дугаар сард Монгол Улсыг ОУИТБС-ын “стандартыг хангасан 4 дэх орон”-оор хүлээн зөвшөөрч, 2011 онд ОУИТБС-ын олон улсын Удирдах хорооны даргын нэрэмжит шагналаар манай улсыг шагнасан байна.

## 2. Даалгаварын зорилго


[Гэрээлэгч этгээд] нь [засгийн газар] болон [ОТАХ]-ийг төлөөлөн ОУИТБС-ын стандартын дагуу Хараат бус хянагч-нэгтгэгчийн үйлчилгээ үзүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, чадвартай бөгөөд итгэл даахуйц компанийг хайж буй болно. Даалгаварын зорилго нь:

Доор заасан ОУИТБС-ын стандарт болон хэсэг 4-ийн дагуу Монгол Улсын ОУИТБС-ын 2014 оны тайланг гаргах.

## 3. Үйлчилгээ, даалгавар болон хүлээлгэн өгөх бүтээгдэхүүн

Хараат бус хянагч-нэгтгэгчийн ажил нь таван үе шатаас бүрдэнэ (зураг 1-ийг харна уу). Хараат бус хянагч-нэгтгэгчийн үе шат бүхэнд хүлээх үүргийг дор дэлгэрэнгүй тусгасан болно.

Зураг 1 – ОУИТБС-ын тайлагналын процесс болон гарах бүтээгдэхүүнүүдийн тойм



ОТАХ нь өмнөх ОУИТБС-ын тайлангууд/бусад судалгаа]-наас үндэслэн Монгол Улсын ОУИТБС-ын 2014 оны тайланд [ҮҮ компаниудын ZZ засгийн газрын агентлагуудад тушаасан ХХ төрлийн төлбөр] хамрагдана гэсэн хүлээлттэй байна. Хараат бус хянагч-нэгтгэгчтэй ажлын эхэнд хэлэлцэж, тодотгох ОТАХ-ийн санал болгож буй ОУИТБС-ын тайлангийн хамрах хүрээг загвар Ажлын даалгаварын хавсралт 1-ийн мэдээллийн хүснэгтэнд тусгасан болно.

### Үе шат 1 – урьдчилсан дүн шинжилгээ ба эхлэлийн тайлан

Оршил: Эхний үе шатын зорилт нь тайлагналын загварууд, өгөгдөл мэдээлэл цуглуулах ажил мөн тайланг гаргах хугацаа гэх мэт ОУИТБС-ын тайлагналын хамрах хүрээг тодорхой тогтооход оршино. ОУИТБС-ын тайлагналыг ОУИТБС-ын стандарт болон ОУИТБС-ын ажиллагааны талаарх ОТАХ-ээс баталсан зорилтууд болон хүлээлттэй нийцүүлж тодорхойлох нь чухал юм. Эхний үе шатны үр дүнг эхлэлийн тайланд тусгана (1.4-ийг харна уу). Хараат бус хянагч-нэгтгэгч нь дараах даалгаваруудыг гүйцэтгэнэ:

- 1.1 Хараат бус хянагч-нэгтгэгч нь олборлох салбарын засаглалын тогтолцоо, татварын бодлого, өмнө нь хийгдсэн хамрах хүрээ тогтоох ажлын үр дүн, өмнөх ОУИТБС-ын тайлангууд болон баталгаажуулалтууд гэх мэт **холбогдох ерөнхий мэдээллийг нягтлан хянана**. (Холбогдох баримт бичгүүдийн жагсаалтыг Хавсралт 2-т тусгасан болно).
- 1.2 Хараат бус хянагч-нэгтгэгч нь **нөхцөл байдлын болон бусад орлоготой холбогдолгүй**

**мэдээллийг хэрхэн ОУИТБС-ын тайланд дүн шинжилгээ хийн тусгах талаар ОТАХ-тэй тохиролцоно.** Уг процедур нь мэдээллийн эх сурвалжийг тодорхой зааж, ишлэсэн байхаар боловсруулагдсан байна. Хараат бус хянагч-нэгтгэгчийн энэ чиглэлээр гүйцэтгэх тодорхой даалгаварууд гэх зэрэг нөхцөл байдлын мэдээлэл цуглуулахад ашиглахаар ОТАХ-ээс санал болгож буй аргачлалын талаарх нэмэлт мэдээллийг загвар ажлын даалгаварын хавсралт 1-т тусгасан болно.

1.3 Хараат бус хянагч-нэгтгэгч нь **ОТАХ-ээс хавсралт 1-т ОУИТБС-ын тайланд оруулахаар санал болгосон төлбөр, орлогуудыг ОУИТБС-ын шаардлага 4-т заасны дагуу хянана.** [ОТАХ нь Хараат бус хянагч-нэгтгэгчэд хамрах хүрээг тогтоох судалгаа явуулах, зарим асуудлуудыг нарийвчлан судлах эсвэл хамрах хүрээг боловсронгуй болгох зэрэг ажил даалгаж болно]. Эхлэлийн тайланд ОТАХ-ийн дараах асуудлаар гаргасан шийдвэрийг тодорхой тусгасан байна:

- Материаллаг байдал болон босгын тодорхойлолт, мөн үүнээс үүдэн шаардлага 4.1(b)-ийн дагуу хамрагдах орлогын урсгалууд.
- Шаардлага 4.1(c)-ийн дагуу үйлдвэрлэлээс төрд ноогдох хувь хэмжээг зарж борлуулах эсвэл бэлэн бус байдлаар олсон бусад орлого.
- Шаардлага 4.1(d)-ийн дагуу дэд бүтцийн хөрөнгө оруулалт ба бартерын солилцооны хамрал.
- Шаардлага 4.1(e)-ийн дагуу нийгмийн хөрөнгө оруулалт, зарцуулалтын хамрал.
- Шаардлага 4.1(f)-ийн дагуу тээврийн орлогын хамрал.[ОТАХ-ийн тохиролцсон бусад чиглэлүүд- шаардлагатай бөгөөд байгаа бол].
- Шаардлага 5.2(e)-ийн дагуу ОУИТБС-ын тайлангийн орлогын задаргааны түвшин ба төрлүүд.

[Хэрэв ОТАХ Хараат бус хянагч-нэгтгэгчээр материаллаг байдал, хамрагдах орлогуудыг тодорхойлох чиглэлээр хамрах хүрээ тогтоох ажил хийлгүүлэх хүсэлтэй бол энд тодорхой даалгаваруудыг тусгах нь зүйтэй. Олон улсын нарийн бичгийн дарга нарын газраас хамрах хүрээ тогтоох загвар ажлын даалгаварыг авч болно.]

1.4 Хараат бус хянагч-нэгтгэгч нь **ОУИТБС-ын шаардлага 4.2 болон ОТАХ-ийн гаргасан хавсралт 1-т тусгасан тодорхойлтын дагуу тайланд хамрагдах компаниуд болон төрийн өмчит аж ахуйн нэгжийг** хянаж нягтална. [Дээр дурдсанчлан, ОТАХ нь хамрах хүрээ тогтоох нарийвчилсэн судалгаа явуулах, тодорхой асуудлыг нарийвчлан судлах эсвэл хамрах хүрээг боловсронгуй болгох зөвлөмж гаргах ажлыг Хараат бус хянагч-нэгтгэгчэд даалгаж болно]. Эхлэлийн тайланд дараахыг тусгасан байна:

- Шаардлага 4.2(a)-ийн дагуу төрд материаллаг төлбөр төлсөн, тайлагнах үүрэгтэй компаниудыг олж тогтоон, жагсаалт гаргах.
- Шаардлага 4.2(a)-ийн дагуу материаллаг төлбөр хүлээн авдаг, тайлагнах үүрэгтэй төрийн өмчит аж ахуй нэгжүүдийг олж тогтоон, жагсаалт гаргах.
- материаллаг байдлын босгонд хүрэхгүй байгаа орлого гэх мэт төлбөрийн урсгал бүрээр хүлээн авсан орлогын нийт дүнг нэг бүрээр нь ОУИТБС-ын хамрах хүрээний дагуу бүрэн тайлагнахад засгийн газарт тулгарч буй бэрхшээлүүдийг олж тогтоох (шаардлага 4.2(b)).
- Шаардлага 4.2(c)-ийн дагуу төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн хийсэн эсвэл хүлээн авсан төлбөрийн нэгтгэл, тайлагналын талаарх ОТАХ-ийн байр суурийг



баталгаажуулна.

- Шаардлага 4.2(d)-ийн дагуу материаллаг байдал болон орон нутагт хийгдэж буй төлбөрийг хэрхэн хамруулах тарлаарх ОТАХ-ийн байр суурийг баталгаажуулах.
- Шаардлага 4.2(e)-ийн дагуу материаллаг байдал болон орон нутаг дахь шилжүүлгийн талаарх ОТАХ-ийн байр суурийг баталгаажуулах.
- [ОТАХ-тэй тохиролцсон бусад чиглэлүүд – шаардлагатай бол].

[Хэрэв ОТАХ хамрагдах аж ахуйн нэгжүүдийг тодорхойлох чиглэлээр хамрах хүрээ тогтоох ажлыг Хараат бус хянагч-нэгтгэгчэд даалгах хүсэлтэй бол энд тодорхой даалгаваруудыг тусгах нь зүйтэй. Олон улсын нарийн бичгийн дарга нарын газраас хамрах хүрээ тогтоох загвар ажлын даалгаварыг авч болно.]

- 1.5 Хараат бус хянагч-нэгтгэгч нь **тайланд хамруулахаар тохиролцсон орлогын урсгалууд болон тайлагнах аж ахуйн нэгжүүдэд (дээрх 1.3-1.4) үндэслэсэн тайлагналын загваруудын талаар** ОТАХ-т зөвлөгөө өгнө. Олон улсын нарийн бичгийн дарга нарын газраас жишиг загваруудыг авч болно. Загварт тохиролцсон босгоос давж буй “төрийн өмчит аж ахуйн нэгжид төлсөн материаллаг бусад аливаа нэг төлбөрийг” тайлагнахыг шаардсан заалт оруулах нь зүйтэй.
- 1.6 Хараат бус хянагч-нэгтгэгч нь **ОУИТБС-ын тайлагналын процесст хамрагдаж буй компаниуд, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн аудит, баталгаажуулалтын процедурыг** шаардлага 5.2(b)-ийн дагуу хянаж, шалгах чиглэлээр ОТАХ-т зөвлөгөө өгнө. Үүнд холбогдох хууль тогтоомж, төлөвлөсөн эсвэл хэрэгжиж буй шинэчлэлүүдийг хянаж, шалгах мөн эдгээр процедурууд олон улсын стандартуудтай нийцэж буй эсэхийг шалгах ажил орно.
- 1.7 Хараат бус хянагч-нэгтгэгч нь **өгөгдөл мэдээллийн чанарыг баталгаажуулах үүднээс хамрагдаж буй компаниуд, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдээс ямар мэдээллийг** шаардлага 5.2(c)-ийн дагуу **Хараат бус хянагч-нэгтгэгчэд гаргаж өгөхийг ОТАХ-ээс шаардах нь зүйтэй** талаар ОТАХ-т зөвлөгөө өгнө. Түүнчлэн Хараат бус хянагч-нэгтгэгч нь компаниуд, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд ашиглагдаж буй хяналт, аудитын хүрээг хэр хэмжээнд найдвартай гэж шийдвэрлэх талаар мэргэжлийн дүгнэлт гаргана. Хараат бус хянагч-нэгтгэгч нь ямар боломжуудыг авч судалсан мөн тухайн баталгаажуулалттай холбоотой үндэслэлээ баримтжуулна. Хэрэв Хараат бус хянагч-нэгтгэгч болон олон талт ажлын хэсгээс шаардлагатай гэж үзвэл дараах баталгаажуулалтыг хийнэ:
- Бөглөсөн тайлагналын маягт нь бүрэн бүтэн, үнэн зөв гэдгийг гэрчилсэн баримт бичигт тухайн компанийн эсвэл төрийн албаны удирдах ажилтан гарын үсэг зурахыг хүсэмжлэх.
  - Хүргүүлсэн мэдээлэл нь бүрэн бүтэн, аудитаар баталгаажсан санхүүгийн тайлантай нийцэж буйг баталгаажуулсан захиаг тухайн компанийн хөндлөнгийн аудитороос хүсэмжлэх. Ийм захидал явуулахыг тухайн компанийн аудиторын ердийн ажлын нэг хэсэг болгох үүднээс ОТАХ нь ийм процедурыг нэвтрүүлж болох юм. Хэрэв зарим компаниуд хуулиар хөндлөнгийн аудитортой байх үүрэг хүлээгээгүй, тиймээс ч ийм баталгаажуулалт хийж өгөх боломжгүй тул энэ асуудлыг нарийн олж тогтоон, төлөвлөсөн эсвэл хэрэгжиж буй шинэчлэлийн хүрээнд авч үзэх нь зүйтэй юм. Хэрэв ач холбогдолтой бөгөөд хэрэгжүүлэх боломжтой гэж үзвэл хамрагдаж буй төрийн өмчит аж ахуйн нэгжүүдээс хөндлөнгийн аудитор эсвэл түүнтэй дүйцэхүйц этгээдээс уг тайлагнасан мэдээлэл нь үнэн зөв гэдгийг гэрчлэх баримт бичиг шаардах нь зүйтэй.

Хараат бус хянагч-нэгтгэгч нь ОУИТБС-ын тайланг цогц, найдвартай гаргах үндэс бүрдүүлэхдээ өөрийн гэсэн дүгнэлт хийж, олон улсын мэргэжлийн стандартуудыг хэрэглэнэ<sup>2</sup>.

- 1.8 Хараат бус хянагч-нэгтгэгч нь **нууцлалын зэрэгт хамаарагдах мэдээллийг хамгаалахтай холбогдолтой зохих заалтуудыг зөвшилцөх** талаар ОТАХ-т зөвлөгөө өгнө.
- 1.9 Хараат бус хянагч-нэгтгэгч нь дээрх 1.1-1.9-д хамрагдах асуудлуудыг ОТАХ-ээр хэлэлцүүлэх зорилгоор эхлэлийн үе шатны үр дүнг **эхлэлийн тайланд** тусгана. Эхлэлийн тайланд шийдэгдээгүй аливаа асуудлууд эсвэл үр дүнтэй хэрэгжүүлэлтэнд тулгарч болзошгүй саад бэрхшээлүүд, мөн эдгээрийг шийдвэрлэхээр ОТАХ-с авч хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээг оруулсан байна.

#### Үе шат 2 – Өгөгдөл мэдээлэл цуглуулах

- 2.1 ОТАХ нь тайлагналын загварыг тараах, бөглөсөн маягтууд болон бусад холбогдох баримт бичгүүд, ОТАХ-ээс цуглуулахыг шаардсан нөхцөл байдалтай холбоотой болон бусад мэдээллийг хамрагдаж буй аж ахуйн нэгжүүдээс цуглуулахыг Хараат бус хянагч-нэгтгэгчэд даалгадаг ба энэ нь хамгийн түгээмэл процедур юм. Засгийн газар нь ихэвчлэн хамрагдаж буй аж ахуйн нэгжийн холбоо барих мэдээллийг өгч, хамрагдах ёстой бүхий л аж ахуйн нэгжийг оролцуулах чиглэлээр Хараат бус хянагч-нэгтгэгчэд дэмжлэг үзүүлдэг.
- 2.2 ОТАХ-ийн өгсөн чиглэлийн дагуу Хараат бус хянагч-нэгтгэгч нь өгөгдөл мэдээлэл хүсэх баримт бичгүүдэд хамрагдаж буй аж ахуй нэгжид зориулсан зохих заавар мөн нэмэлт мэдээлэл, туслалцаа хаанаас авах талаарх мэдээллийг оруулсан байх нөхцлийг хангах зорилгоор зөвлөгөө өгөх үүрэг хүлээж болно. Хараат бус хянагч-нэгтгэгч нь аливаа зөрүү эсвэл нийлэхгүй байгаа тоо баримтыг тодруулахаар хамрагдаж буй аж ахуйн нэгжүүдтэй шууд холбогдох үүрэгтэй.

#### Үе шат 3 – Анхан шатны нэгтгэл ба анхан шатны нэгтгэлийн тайлан

- 3.1 Хараат бус хянагч-нэгтгэгч нь хамрагдаж буй аж ахуй нэгжүүдийн өгсөн тайлангуудыг нэгтгэж, өгөгдлийн сан үүсгэнэ.
- 3.2 Хараат бус хянагч-нэгтгэгч нь хамрах хүрээний дагуу хамрагдаж буй аж ахуй нэгжүүдийг тайлагнасан мэдээллийг нэгтгэж, аливаа зөрүү (үүнд буцаан олгогдсон зөрүү орно)-г олж тогтооно.
- 3.3 Хараат бус хянагч-нэгтгэгч нь хамрах хүрээний дагуу тайлагнасан (засвар хийгдээгүй) дүнгүүдэ тулгуурлан анхан шатны нэгтгэл тайлан бэлтгэж, ОТАХ-т хүргүүлнэ.
- 3.4 [Хараат бус хянагч-нэгтгэгч нь нийт орлогын Х%-тай тэнцэх зөрүүнээс дээш хэмжээний зөрүүг олж тогтооно]
- 3.5 [Хараат бус хянагч-нэгтгэгчийн цуглуулах эсвэл Засгийн газар юмуу ОТАХ-ээс Хараат бус хянагч-нэгтгэгчэд өгөх нөхцөл байдлын болон бусад мэдээллийн хувьд: Хараат бус хянагч-нэгтгэгч нь Засгийн газар, ОТАХ эсвэл хамрагдаж буй аж ахуй нэгжүүдийн

<sup>2</sup> Жишээлбэл, ISA 505 relative to external confirmations; ISA 530 relative to audit sampling; ISA 500 relative to audit evidence; ISRS 44000 relative to the engagement to perform agreed-upon procedures regarding financial information and 4410 relative to compilation engagements.

цуглуулсан мэдээллийг нэгтгэж, энэхүү мэдээллийг тайлагнахаар ОТАХ-тэй зөвшилцсөн загварын дагуу нөхцөл байдал болон бусад цугларсан мэдээлэлд үндэслэсэн анхан шатны тайлан бэлтгэнэ.]

#### Үе шат 4 – Зөрүүг шалгаж, Хараат бус хянагч-нэгтгэгчийн тайлангийн төслийг бэлтгэх

- 4.1 Хараат бус хянагч-нэгтгэгч нь тайлагнасан датанд гарсан аливаа зөрүүг тодруулахаар тайлагнасан аж ахуйн нэгжтэй шууд холбогдож ажиллах үүрэгтэй.
- 4.2 Хараат бус хянагч-нэгтгэгч нь тайлагнасан аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг нэгтгэсэн, зөрүүг олж тогтоосон, ОТАХ-ийн хүсэмжилсэн нөхцөл байдлын болон бусад мэдээллийг агуулсан Хараат бус хянагч-нэгтгэгчийн тайлангийн төслийг боловсруулна.
- 4.3 Хараат бус хянагч-нэгтгэгчийн тайлангийн төсөлд:
- a) компаниудын төлсөн төлбөр, Засгийн газрын хүлээн авсан орлогыг нэгтгэхэд ашигласан аргачлалын талаар тусгаж, олон улсын мэргэжлийн стандартыг ашигласан гэдгээ харуулна.
  - b) орлогын урсгал бүрийг холбогдох материаллаг байдал болон босготой тодорхойлсон тодорхойлолтын хамт тусгана (шаардлага 4.1).
  - c) Хараат бус хянагч-нэгтгэгчийн гүйцэтгэсэн ажлын хураангуй, хийсэн үнэлгээний хязгаарлагдмал байдал гэх мэт Хараат бус хянагч-нэгтгэгчийн бэлтгэсэн өгөгдлийн сангийн бүрэн бүтэн, найдвартай байдлын талаар хийсэн үнэлгээг тусгана.
  - d) Шаардлага 4.2(b)-ийн дагуу засгийн газраас тайлагнасан нийт орлогод үндэслэн нэгтгэлийн ажлын хамаарлын хүрээг тусгана.
  - e) ОУИТБС-ын тайлагналын процессийн хамрах хүрээнд хамаарагдаж буй бүхий л компаниуд, төрийн өмчит аж ахуйн нэгжүүд хүсэмжилсэн мэдээллийг өгсөн эсэхийг үнэлсэн үнэлгээг тусгана. Хараат бус хянагч-нэгтгэгчэд тайлагнахад гарч буй аливаа дутагдалтай тал эсвэл зөрүүг ОУИТБС-ын тайланд тусгана. Үүнд батлагдсан процедурыг зөрчсөн аж ахуйн нэгжийн нэрийг дурдах, мөн энэ нь тайлангийн бүрэн бүтэн байдалд ноцтой нөлөө үзүүлсэн эсэх зэрэг орно (шаардлага 5.3(d)).
  - f) Хамрагдаж буй компаниуд, төрийн өмчит аж ахуйн нэгжүүд нь ОУИТБС-ын тайлангийн жилд хамрагдаж буй сахүүгийн тайлант жилийн санхүүгийн тайлангуудаа аудиторар баталгаажуулсан эсэхийг тусгана. Аливаа зөрүү эсвэл дутагдлыг дурдсан байна. Хэрэв аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан нь нийтэд ил болсон бол ОУИТБС-ын тайланд уншигчдыг энэхүү мэдээллийг хэрхэн авч болох талаар зааварчилсан байх нь зүйтэй. (шаардлага 5.3(e)).
- 4.4 Хэрэв өмнөх ОУИТБС-ын тайланд засаж залруулах арга хэмжээ, шинэчлэлийг зөвлөсөн байвал Хараат бус хянагч-нэгтгэгч нь тэдгээр арга хэмжээний хэрэгжилтийн ахицын талаар дурдана (шаардлага 5.3(e)). [Хараат бус хянагч-нэгтгэгч нь аудитын практик болон түүнийг олон улсын стандартуудтай ойртуулахад шаардлагатай шинэчлэлүүдийн талаарх зөвлөмж гэх мэт тайлагналын процессийг сайжруулах чиглэлээр зөвлөмжүүд өгөх нь зүйтэй.]
- 4.5 Хараат бус хянагч-нэгтгэгч нь Хараат бус хянагч-нэгтгэгчийн үйлчилгээний загвар ажлын удирдамжийг ОУИТБС-ын стандарттай нийцүүлэн сайжруулах чиглэлээр ОУИТБС-ын Удирдах зөвлөлд зөвлөмжүүд хүргүүлэх нь зүйтэй.

#### Үе шат 5 – Хараат бус хянагч-нэгтгэгчийн эцсийн тайлан

- 5.1 Хараат бус хянагч-нэгтгэгч нь эцсийн тайлантай хамт хэвлэж болох цахим материалуудыг (файл) бэлтгэнэ.
- 5.2 [Хараат бус хянагч-нэгтгэгч нь машинаар унших боломжтой файлууд мөн/эсвэл код



боловсруулна эсвэл ОУИТБС-ын тайлангууд болон дата файлуудад тэмдэглэгээ (tag) үүсгэнэ].

- 5.3 ОТАХ-ээр батлуулсны дараа, Хараат бус хянагч-нэгтгэгч нь ОУИТБС-ын тайлангийн хураангуй материалыг Олон улсын нарийн бичгийн дарга нарын газарт түүнээс батлан гаргасан стандарт тайлангийн загварыг ашиглан хүргүүлнэ (шаардлага 5.3(b)).

Хараат бус хянагч-нэгтгэгч нь эцсийн тайланг зөвхөн ОТАХ-ийн зааварчилгааг авсны дараа нийтэд ил болгоно/хэвлэнэ. Тайланг хэвлэлтэнд гарахаас өмнө ОТАХ батална. Хэрэв Хараат бус хянагч-нэгтгэгчээс бусад оролцогч тал тайланд санал, байр сууриа ОУИТБС-ын тайланд оруулахыг хүсвэл бичиж буй эх сурвалжийг тодорхой бичсэн байна.

#### **4. Хараат бус хянагч-нэгтгэгчэд тавих мэргэжлийн шаардлага**

Хараат бус хянагч-нэгтгэгч нь компаниудын төлсөн төлбөр, засгийн газрын хүлээн авсан орлогыг нэгтгэхдээ заавал олон улсын мэргэжлийн стандартуудыг ашиглана (шаардлага 5.1). Хараат бус хянагч-нэгтгэгч нь ОТАХ-ээс сайн, найдвартай бөгөөд мэргэжлийн хувьд чадварлаг гэсэн дүгнэлт авсан байх шаардлагатай (ib id). Тендерт оролцогсод нэгтгэх/тайлан гаргахад ашиглах процедуртаа зохих мэргэжлийн стандартуудыг заавал баримтлан ажиллана (мөн түүнийг хэрхэн баримтлахаа харуулна).

Хараат бус хянагч-нэгтгэгч нь дараах чадвараа нотлон харуулна:

Хараат бус хянагч нэгтгэгч нь гадаад, дотоодын аудитын компаниудын түншлэл (консерцум) байх ба дараах шаардлагыг хангасан байна:

а/ нягтлан бодохын мэргэжлээрээ олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн удирдагчтай (олон нийтийн эрх бүхий нягтлан бодогч, мэргэшсэн нягтлан бодогч, эсхүл мэргэшсэн нягтлан бодогчтой адил түвшиний ур чадвартай) болох нь нотлогдсон байх;

б/ Олон улсын Нягтлан бодогчдын холбоонд харьяалагдах нягтлан бодохын байгууллагын мэргэшсэн гишүүн нягтлан бодогчтой байна. Компани нь шаардлага хангасан ажилтнуудтай байх хийгээд үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх чадавхитай байна;

в/ ОУИТБС-ын зохих мэдлэгтэй, энэ чиглэлээр өмнө нь тайлангийн нэгтгэл болон баталгаажуулалт хийж байсан туршлагатай байх;

г/ Түншлэл (Консерцумд) оролцох дотоодын аудитын компани нь аудит хийх тусгай зөвшөөрлийг Монгол Улсын Сангийн яамнаас авсан, тэр нь хүчинтэй байх ёстой. Оролцох сонирхолоо илэрхийлэхдээ тусгай зөвшөөрлийн хуулбарыг хавсралтаар заавал ирүүлнэ;

д/ Түншлэл (Консерцум) байгуулсан тухай нотлох баримтыг сонирхолоо илэрхийлэхдээ хуулбарыг нь заавал ирүүлнэ. Хэрэв өөрийн салбар, эсхүл охин компанитай хамтран гүйцэтгэх бол хамтран хэрэгжүүлэх тухай нотолгоог заавал ирүүлнэ;

Энэхүү ажлыг чанартай, хараат бус байдлаар явуулах үүднээс Хараат бус хянагч-нэгтгэгч нь тендерийн саналдаа бодит болон болзошгүй ашиг сонирхлын зөрчил, түүнээс яаж зайлсхийх боломжтой талаарх мэдээллийн хамт тусгах шаардлагатай.

#### **5. Тайлагналын шаардлагууд болон бүтээгдэхүүн хүлээлгэн өгөх хугацаа**

Уг даалгавар нь 2015 оны 3 дугаар сарын 11- ний боловсруулан дуусган батлав. ОУИТБС-ын 2014 оны тайланг 2015 оны 10 дугаар сарын 31- ний дотор батлан гаргасан байна.

Гэрээнд гарын үсэг зурах	2015,05,15
Эхлэлийн үе	2015,05,15-06,15
Эхлэлийн тайлан	2015,06,30
Дата цуглуулалт ба анхан шатны нэгтгэл	2015,06,30-08,30
Анхан шатны нэгтгэлийн тайлан	2015,09,30
Тайлангийн төсөл	2015,10,15
Эцсийн тайлан	2015,10,31

Төлбөрийг дараах байдлаар хэсэгчлэн хийнэ:

[10%> -ийг гэрээнд гарын үсэг зурсны дараа  
 10%> -ийг эхлэлийн тайлан хүлээлгэн өгсний дараа  
 30%> -ийг тайлангийн төсөл хүлээлгэн өгсний дараа  
 50%> -ийг ОУИТБС-ын тайланг ОТАХ-ээс баталж, нийтэлсний дараа]

## 6. Харилцагчийн санал ба нөгөө талыг хариуцсан ажилтан

[Тайлагналын шугам, Хараат бус хянагч-нэгтгэгчэд даалгаварын үеээр үзүүлэх дэмжлэг, бусад логистик болон захиргааны шинжтэй зохицуулалтуудын талаарх мэдээллийг оруулна.]

## 7. Сонгон шалгаруулалт, гэрээ байгуулах

Хараат бус хянагч- нэгтгэгчийг Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 39 дүгээр заалтын дагуу Зөвлөх сонгох хосолмол үнэлгээний аргаар сонгон шалгаруулна. Гэрээ байгуулах эрх бүхий байгууллага нь Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын ажлын алба байна.

## 8. Сонирхолоо илэрхийлэх

Энэхүү тендерт оролцох сонирхолоо дээр дурдсан чадвар, шаардлагын дагуу баримт бичгүүдээ монгол болон англи хэл дээр бүрдүүлэн 2015 оны 4 дугаар сарын 10- ны 15<sup>00</sup> цагаас өмнө Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын ажлын албанд ирүүлнэ үү.

Хаяг: Монголын Олборлох үйлдвэрлэлийн Ил тод байдлын санаачлагын ажлын алба

Туушин компанийн төв байр, 314 тоот, Ерөнхий сайд А. Амарын гудамж,

Улаанбаатар хот, 210620А, Монгол улс

Утас 976- 70 11 05 25, Факс 976- 70 11 01 55,

Цахим шуудан: [eiti.secretariat.mn@gmail.com](mailto:eiti.secretariat.mn@gmail.com), Цахим хуудас: [www.eitimongolia.mn](http://www.eitimongolia.mn)

## Хавсралт 1 – Үйлчилгээний хамрах хүрээний мэдээллийн хуудас

ОТАХ нь [хамрах хүрээ тогтоох тайлан/өмнөх ОУИТБС-ын тайлангууд /бусад судалгаанд үндэслэн дараах хамрах хүрээг ОУИТБС-д санал болгож буй болно.

### 1. Нөхцөл байдлын мэдээлэл

Хараат бус хянагч-нэгтгэгч нь доорх нөхцөл байдлын мэдээллийг ОУИТБС-ын шаардлага 3-ын дагуу цуглуулах үүрэг хүлээнэ.

<b>ОУИТБС-ын тайланд тусгагдах нөхцөл байдлын мэдээлэл</b>	<b>Хараат бус хянагч-нэгтгэгчийн гүйцэтгэх ажлын талаарх тайлбар</b>
Олборлох салбарын эрх зүйн зохицуулалт, төсвийн бодлогын талаарх тодорхой мэдээлэл (шаардлага 3.2), ялангуяа ОУИТБС-ын тайланд тайлагнадаг мэдээлэлтэй холбоотой хуулиуд	...
Олборлох салбарын талаарх товч танилцуулга, үүнд хайгуулын томоохон үйл ажиллагааны талаарх мэдээлэл орно (шаардлага 3.3)	...
ОУИТБС-ын тайланд хамрагдах төсвийн жилд олборлох үйлдвэрлэлийн эдийн засагт оруулсан хувь нэмрийн талаарх боломжтой мэдээллүүд (шаардлага 3.4)	...
ОУИТБС-ын тайланд хамрагдах төсвийн жилийн олборлолтын талаарх мэдээлэл (шаардлага 3.5)	...
Олборлох салбар дахь төрийн оролцооны талаарх мэдээлэл (шаардлага 3.6) <sup>3</sup>	...
Олборлох салбараас олсон орлогын хуваарилалт (шаардлага 3.7);	...
ОТАХ-ээс орлогын менежмент, зарцуулалтын талаар хүсэлт тавьсан нэмэлт мэдээлэл (шаардлага 3.8)	...

<sup>3</sup> Зааварчилгаа 18: ОУИТБС-ын тайлагнал дахь төрийн өмчит компанийн оролцоо, [https://eiti.org/files/GN/Guidance\\_note\\_18\\_SOEs\\_EN.pdf](https://eiti.org/files/GN/Guidance_note_18_SOEs_EN.pdf)

Лиценз олгох явц, бүртгэл (шаардлага 3.9) <sup>4</sup> мөн лиценз олголтын талаарх мэдээлэл (шаардлага 3.10) <sup>5</sup>	...
Эцсийн зэмшигчийн талаарх ОТАХ-ээс хүсэмжилсэн аливаа мэдээлэл (шаардлага 3.11) <sup>6</sup>	...
Гэрээний талаарх ОТАХ-ээс хүсэмжилсэн аливаа мэдээлэл (шаардлага 3.12) <sup>7</sup>	...
[ОТАХ-ээс гаргахаар тохиролцсон нөхцөл байдлын талаарх бусад мэдээллийг оруулна]	...

## 2. ОУИТБС-ын тайланд хамрагдах татвар, орлогууд (шаардлага 4.1)<sup>8</sup>

Орлогын урсгал	Хараат бус хянагч-нэгтгэгчийн гүйцэтгэх ажлын талаарх тайлбар
...	...

<sup>4</sup> Зааварчилгаа 3: Лицензийн бүртгэл, <https://eiti.org/files/GN/Guidance-note-3-License-Registers.pdf>

<sup>5</sup> Зааварчилгаа 4: Лиценз олголт, [https://eiti.org/files/Guidance%20note%204%20-%20License%20Allocations\\_FINAL\\_20131113.pdf](https://eiti.org/files/Guidance%20note%204%20-%20License%20Allocations_FINAL_20131113.pdf)

<sup>6</sup> Эцсийн эзэмшигчийн туршилтын ажлын даалгавар, <https://eiti.org/files/TOR%20Beneficial%20ownership%20pilot.pdf>, мөн эцсийн эзэмшигчийн загвар мэдүүлгийн хуудас, <https://eiti.org/files/Template-beneficial-ownership-declaration-form.doc>

<sup>7</sup> Зааварчилгаа 7: Гэрээний ил тод байдал, <https://eiti.org/files/Guidance-note-7-Contract-transparency.pdf>

<sup>8</sup> Зааварчилгаа 13: материаллаг байдал, тайлагналын босго болон тайлагнах аж ахуйн нэгжүүдийн тодорхойлолт, [https://eiti.org/files/Guidance%20note%200n%20defining%20materiality\\_o.pdf](https://eiti.org/files/Guidance%20note%200n%20defining%20materiality_o.pdf)


3. Тайлагнах аж ахуйн нэгжүүд (компаниуд ба засгийн газрын агентлагууд) (шаардлага 4.2)

4. Хамрах хүрээний талаарх нэмэлт тайлбар

Материаллаг байдал ба орон нутагт хийж буй төлбөрийн хамралт ( <u>шаардлага 4.2(d)</u> ) <sup>9</sup>	
Төрийн өмчит компаниудын хийж буй болон хүлээн авч буй төлбөрийн тайлагнал, нэгтгэл ( <u>шаардлага 4.2(c)</u> ) <sup>10</sup>	
Материаллаг байдал ба орон нутагт хийж буй шилжүүлэг ( <u>шаардлага 4.2(e)</u> ) <sup>11</sup>	

<sup>9</sup> Зааварчилгаа 10: Орон нутгийн тайлагнал, <https://eiti.org/files/Guidance-note-10-Subnationalreporting.pdf>

<sup>10</sup> Зааварчилгаа 18: ОУИТБС-ын тайлагнал дахь төрийн өмчит компаниудын оролцоо, [https://eiti.org/files/GN/Guidance\\_note\\_18\\_SOEs\\_EN.pdf](https://eiti.org/files/GN/Guidance_note_18_SOEs_EN.pdf)

<sup>11</sup> Зааварчилгаа 10: Орон нутгийн тайлагнал, <https://eiti.org/files/Guidance-note-10-Subnationalreporting.pdf>



## Хавсралт 2 – Дагалдах баримт бичиг

Холбогдох хууль тогтоомж гэх мэт олборлох салбарын засаглалын тогтолцоо ба татварын бодлогын талаарх баримт бичгүүд

- [...]
- [...]
- [...]

ОУИТБС-ын ажлын төлөвлөгөө ба бусад баримт бичгүүд

- [...]
- [...]
- [...]

Хамрах хүрээ тогтоох урьдчилсан ажлын үр дүн

- [...]

Өмнөх ОУИТБС-ын тайлангууд

- [...]
- [...]

Өмнөх ОУИТБС-ын тайлангуудын талаарх тайлбар/мэдээлэл

- [...]
- [...]

Баталгаажуулалтын тайлан

- [...]
- [...]

Бусад холбогдох баримт бичгүүд (жилийн үйл ажиллагааны тайлан г.м)

- [...]
- [...]